

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Сүмбэр сум

Албан хаагч, ажилчдын "Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", "Сургалтын хөтөлбөр", 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 17, 18 дугаар бүлэг, төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь :


1. Байгууллагын албан хаагч, ажилчдын "Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-г 1 хавсралтаар, "Төрийн албан хаагч, ажилчдын Сургалтын хөтөлбөр"-г 2 дугаар хавсралтаар, Албан хаагч, ажилчдын 2020 онд хэрэгжүүлэх "Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-г 3 дугаар хавсралтаар, Албан хаагч, ажилчдын 2020 онд хэрэгжүүлэх "Сургалтын төлөвлөгөө"-г 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн тайлагнахыг Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах албаны дарга /М.Батдэлгэр/-т даалгасугай

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг төсөвт жил бүр тусгаж байхыг ня-бо /Б.Лүнгэрэгжанцан/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БУЯНТОГТОХ



:\Documents and Settings\ tushaal

1422010002

Биеийн тамир, спортын газрын даргын  
20<sup>до</sup> оны 01 дугаар сарын 5 өдрийн  
А/ас тоот тушаалын 1 хавсралт

УСХС 0009 901857

## Биеийн тамир, спортын газрын албан хаагч, ажилчдын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр

### Нэг: Нийтлэг үндэслэл

Энэхүү дэд хөтөлбөрийн агуулга зорилтыг хүрээнд аймгийн Биеийн тамир, спортын газрын албан хаагч, ажилчдын ажиллах орчин нөхцлийн баталгааг хангах, мэргэжлийн хэрэглэл материал, тоног төхөөрөмжийн хангамж, мэргэжил мэдлэг, ур чадварыг дээшүүлэх үйл ажиллагааны чиглэл, үе шат хөдөлмөрийн харилцаатай холбогдон үүсэх нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар байгууллагын баримтлах бодлого тусгагдсан болно.

**Өнөөгийн байдал:** Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газар нь 18 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс захиргааны албан хаагч-3, үйлчилгээний албан хаагч-15 байна. хүйсний хувьд эрэгтэй-11, эмэгтэй-7 албан хаагч, ажилчид байна. Боловсролын түвшингээр дээд боловсролтой 11, бүрэн дунд боловсролтой-7 албан хаагчид байна. Албан хаагч, ажилчдын үндсэн цалингийн дундаж 620.000 мянган төгрөг бөгөөд ажлын үр дүнгээс хамаарч 10-25 хүртэлх хувийн нэмэгдлийг тогтмол олгож байна. Ажилтнуудын өрхийн ам бүлийн бүтцийн тодорхойлбол 3 хүртэл албан хаагч, 4-6 ам бүлтэй 9 албан хаагч, ажилчид байна. Мөн байр орон сууцтай 5 албагн хаагч, 13 албан хаагч нь одоогоор байр орон сууцгүй байна.

**Төрийн албан хаагч, ажилчдын ажиллаж буй өнөөгийн нөхцөл ба шаардлага:** 2004 эхлэн албан хаагч, мэргэжилтнүүдийн албан өрөө, бөхийн болон боксын заал, бялдаржуулах спортын танхим, барилгын дотор гадна засвар, сантехникийн шинэчлэл, спортын заалны шалны засвар, коридор, барилгын дээвэр зэргийн засвар тохижилт, мэргэжилтнүүдийн албан хэрэгцээг хангах компьютер, бусад тоног төхөөрөмжүүд, спортын секцүүдийн сургалт дасгалжуулалт явуулах шаардлага хангасан хэрэглэл материал хангах зэрэгт нийт 72 сая төгрөг зарцуулаад байна. Ингэснээр ажлын үр дүнд сургалт дасгалжуулалт, ажил үйлчилгээ явуулах эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан ажлын ая тухтай орчин нөхцөл бүрэн бүрэлдсэн байна. Тэмдэглэлт ой, баяр ёслол, аялалыг байгууллагын албан хаагч, ажилчдын хүрээнд чөлөөт цагаа өнгөрүүлэх, биеийн тамирын болон бусад төрлийн уралдаан тэмцээн зохиох зэрэг нэгдсэн байдлаар зохион байгуулддаг.

**Нийгмийн баталгаа:** Байгууллагын албан хаагч, ажилчдын нийгмийн баталгааны талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нь төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд тэдний цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын үр дүнг дүгнэн ур чадварын нэмэгдэл олгох, төрийн зардлаар мэргэшүүлэх, мэргэжлээ дээшүүлэх, эрүүл мэндийг болон нийгмийн даатгалын хураамжийг зохих хувийг төр хариуцах, ээлжийн амралтаар өөрийн эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах зам зардлыг олгох, албан хаагч, ажилчдын ар гэрт гачигдал гарсан тохиолдох үед буцалтгүй тусламжийг олгох зэрэг үйл ажиллагаанд чиглэгдэж байна.

Мөн сар бүр хамтын сангийн хуримтлалыг бүрдүүлэн амьдралын нөхцлийг дээшүүлэх, амьжиргаанд нь туслах чиглэлд зарцуулж байна.

**Хоёр: Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах, мэдлэг боловсрол, ур чадварыг дээшүүлэх, амралт сувиллын үйлчилгээнд хамруулах зэрэгт оршино.

**Гурав: Хөтөлбөрийн зорилт**

1. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжоор хангана.
2. Төрийн албан хаагчдын цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшуулыг хууль тогтоомжийн дагуу олгох.
3. Албан хаагч, ажилчдын амьжиргааны түвшинг дээшүүлэх, хөнгөлөлт үзүүлэх.
4. Албан хаагч, ажилчдыг эрүүл мэндийн хүртээмж, чанарыг дээшүүлэх.
5. Албан хаагч, ажилчдын мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшүүлэх.
6. Албан хаагч, ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх.

**Дөрөв: хөтөлбөрийн хугацаа**

Хөтөлбөрийн хугацааг 2020-2024 онд жил бүр төлөвлөн хэрэгжүүлнэ.

**Тав: Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга зам**

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлагын зохицуулалтаар хангах, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг байгууллагын даргын зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.
2. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар албан хаагч, ажилчдын санал хүсэлтийг тогтмол хүлээн авч шийдвэрлэнэ.
4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр гаргаж албан хаагч, ажилчдад тайлагнана.

**Зургаа: Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээ**

**1-р зорилтын хүрээнд хийх ажил:**

- Албан хаагч, ажилчдын унаа, хоолны мөнгийг зохих журмын дагуу олгох. Мэргэжилтнүүдийн нормын спортын хувцас, хэрэглэлийг нормт хугацаанд нь олгох.
- Албан хаагчдыг энгэрийн тэмдэг, ажлын үнэмлэхтэй болгох.
- Албан өрөө, спортын заал танхимын эрүүл ахуйн нөхцлийг шаардлагын түвшинд байлгах.

**2-р зорилтын хүрээнд хийх ажил:**

- Төрийн албаны тухай хуульд заасан хөнгөлөлтүүдийг хуулийн шаардлагад нийцүүлэн олгох.
- Ажил хавсран гүйцэтгэсэн буюу түр орлон гүйцэтгэсэн тохиолдолд 40 хүртэл хувийн нэмэгдэл олгох.
- Хамт олны зөвлөлийн "Хамтын сан"-г журмын дагуу албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, хамт олноо хошуучлан ажилласан нэг албан хаагчийг байгууллагын аваргаар тодруулан 1 сарын цалингаар шагнах.
- Албан хаагч, ажилчдад түлээ нүүрсний асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

**3-р зорилтын хүрээнд хийх ажил:**

- Албан хаагч, ажилчдыг 2 жил тутамд нэг удаа нарийн мэргэжлийн эмч нарийн үзлэгт хамруулах.

- Шаардлагатай албан хаагч, ажилчдад эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, амралт сувилалд явахад дэмжлэг үзүүлэх.

- Улиралд нэг удаа албан хаагчдад 1500 төгрөгийн тооцож витаминжүүлэлтийн хангалт хийх.

**4-р зорилын хүрээнд хийх ажил:**

- Мэргэжилтнүүдийн албан хэрэгцээний компьютерээр хангах.
- Чийрэгжүүлэлтийн өрөө болон усан спорт сургалтын төв хамрагдах.
- Сургалт дасгалжуулалт явуулах шаардлага хангасан спортын хэрэглэл материалаар хангах.

- Мэргэжилтнүүдийг жилд 1-ээс доошгүй удаа бүс, улс, олон улсын сургалтад хамруулах.

- Тэмдэглэлт ой, уламжлалт баяр, байгууллагын аялалыг нэгдсэн журмаар амралт, уралдаан тэмцээний хэлбэрээр тэмдэглэх.

- Тэдний чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх санал санаачлагыг дэмжих.

- Амралтын өрөөтэй болох.

- Албан хаагч, ажилчдыг орон сууцжуулах ажлын эхлүүлэх, дэмжлэг үзүүлэх.

**Долоо: Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг байгууллагын жил бүрийн төсөвт тусгах, хамтын сангийн хуримтлал бий болгох, дотоод бололцоогоо ашиглах зэргээр шийдвэрлэнэ.

**Найм: хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих**

1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хянах, биелэлтийг дүгнэх үүргийг байгууллагын даргын зөвлөл хариуцна.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн дараах үзүүлэлтээр тодорхойлогдоно.

Үүнд:

- Төрийн албан хаагчийн тогтвор суурьшил ажиллах, эрхэлсэн ажлын үр бүтээл дээшүүлнэ.

- Ажиллах нөхцөл боломж сайжирна.

- Ажлын идэвхи, ажиллах урам зориг сэргэнэ.

**Хөтөлбөр боловсруулсан:**

**БТСБХЗАлбаны дарга**



**М.Батдэлгэр**

Биеийн тамир, спортын газрын даргын  
2020 оны 01 дугаар сарын 5 өдрийн  
1/02 тоот тушаалын... 2... хавсралт



Албан хаагч, ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд  
2020 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөө

2020.01.02

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Улс, олон улсын тэмцээн, уралдаанд амжилттай оролцож амжилт гаргасан багш, дасгалжуулагч, эрхэлсэн ажилдаа идвэхи санаачлагатай ажилласан ажилчдыг шагнаж урамшуулах.	Жилдээ	Нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан
2	Албан хаагч, ажилчдын дунд соёл, спортын тэмцээн, уралдааныг зохион байгуулах.	Жилдээ	ӨУАХБИБТС хариуцсан мэргэжилтэн, Б.Баярмаа
3	Багш, дасгалжуулагч нарыг спортын хэрэглэл материалаар хангах.	Жилдээ	Нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан
4	Албан хаагч, ажилчдад унааны зардал-1200 төгрөг, хоолны зардал-3000 төгрөгийг олгоно.	Жилдээ	Нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан
5	Мэргэжилтнүүдийн нормын спортын хувцас, хэрэглэлийг нормт хугацаанд нь олгох.	3-р улиралд	Нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан Нярав Н.Эрдэнэцэцэг
6	Нарийн мэргэжлийн эмч нар болон эрүүл мэндийн үзлэгт албан хаагч, ажилчдыг бүгдыг хамруулах.	2-р улиралд	ӨУАХБИБТС хариуцсан мэргэжилтэн, Б.Баярмаа Нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан
7	Албан хаагч, ажилчдыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх үүднээс усан спортын төвд 7 хоногийн 4 дахь өдөр, спорт зааланд 7 хоногийн 3 дахь өдөр бүр хичээллэх.	Жилдээ	Дасгалжуулагч Ш.Наранбаяр
8	Ханиад томууны цагаар ажилтан, албан хаагчдад халуун аарц, чацаргана өгөх, витаминжуулах.	1,4-р улиралд	Нярав Н.Эрдэнэцэцэг
9	Хүүхдийн баяраар ажилчдын 16 нас хүрээгүй хүүхдүүдийн дунд хөгжөөнч тоглоом, тэмцээн зохион байгуулж, бэлэг өгнө.	3-р улиралд	Үйлчлэгч М.Туул Г.Зоригтбаатар

Төлөвлөгөө гаргасан:

БТСБХЗАлбаны дарга

М.Батдэлгэр